



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,
Утас: 26 04 37, Факс: (976) 6226 3230,
E-mail: info@audit.gov.mn, http://www.audit.mn

ЭХ ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН
ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЗАХИРАЛ
Ш.ЭНХТӨР ТАНАА

2017.02.20 № 3/266
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15.1.1, Төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасны дагуу 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон холбогдох бусад тайлбар тодруулга бүхий санхүүгийн тайланд аудит хийв.

Үүрэг хариуцлагын талаархи мэдээлэл

Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн удирдлага нь Төсвийн тухай хуулийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангууд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Нягтлан бодогчдын олон улсын холбооноос баталсан Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлж Монгол Улсын Үндэсний аудитын газраас гаргасан Санхүүгийн аудитын гарын авлагын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, гарын авлагын шаардлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх явдал болно.

Аудитаар санхүүгийн тайлан дахь дүн хэмжээ болон илчлэл тодруулгыг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгадаг. Түүнчлэн аудитаар удирдлагын ашигласан нягтлан бодох бүртгэлийн зарчим, хийсэн чухал тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлдэг.

Бидний хийсэн аудит санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

Зөрчилгүй санал дүгнэлт

Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, бодитой илэрхийлсэн байна.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

С.ЭНХЗАЯА

УХА0122
\\10.10.10.20\Bichig_Kheregl\Yawsan_Bichig\2017\0220SAG37Docx

073185



УАГ
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

ЭХ ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН 2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

АУДИТЫН ТАЙЛАН

**Нэмэлт мэдээлэл авахыг
хүсвэл дараах хаягаар
харилцана уу:**

Санхүүгийн аудитын
газрын дарга С.Энхзаяа
Утас: 261663

Аудитын менежер
Н.Золзаяа
Утас: 260512

Аудитор Н.Нямдаваа
Утас: 260512

“Ньюбаланс аудит” ХХК
Аудитор Д.Гэрэлчулуун

Үндэсний аудитын газар
Засгийн газрын IY байр
Бага тойруу 6
Улаанбаатар-46
Монгол улс

Хавсралт 1: Агуулга

Хавсралт 2: Аудитын гэрчилгээ

Хавсралт 3: Менежментийн захидал

Хавсралт 4: Аудит хийсэн санхүүгийн тайлан

Хавсралт 5: Төсвийн гүйцэтгэлийн тайлан

АГУУЛГА

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Дотоод хяналт
6. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
7. Шилэн дансны мэдээлэл
8. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
9. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
10. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:
11. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:
12. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
13. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
14. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
15. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
16. Зөвлөмж
17. Аудитын гэрчилгээний талаарх дүгнэлт

Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1, Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1-д заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд /ҮАГ-2017/.../СТА-ТШЗ/ аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2016 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн Сайдын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2016 оны санхүүгийн тайлангийн аудитыг 2016 оны 11 дүгээр сарын 25-наас 2017 оны 2 дугаар сарын 14-ны хооронд хийхээр төлөвлөн “Ньюбаланс Аудит” ХХК-ийн 1 дугаар багийн аудиторууд хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв 2016 оны санхүүгийн тайлангаа 2017 оны 02 дүгээр сарын 01-нд 74 тоот албан бичгээр ирүүлсэн.

Үндэсний аудитын газар аудитын тайланг 2016 оны 2 дугаар сарын 25-нд Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн удирдлагад гардуулав.

Байгууллагын хууль, эрх зүйн орчин:

Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн төсөв захирагч нь Монгол улсын Төсвийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хуулиудын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна. Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хууль, тогтоомж, түүнд нийцүүлэн гарсан журам, зааварт өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:

Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв нь улсын хэмжээнд эх, эмэгтэйчүүд, ураг, нярай, хүүхдэд төрөлжсөн нарийн мэргэжлийн тусламж, үйлчилгээ үзүүлэх эмнэлэг, поликлиник, лаборатори, тасралтгүй үйл ажиллагааг туслан, дэмжих үүрэг бүхий албад, нэгж, эрдэм шинжилгээний салбартай эмчилгээ, оношлогоо, сургалт, эрдэм судлалын ажил эрхлэн, мэргэжил арга зүйн гурав дахь шатны лавлагаа, тусламж үзүүлэх төв юм.

Эх хүүхдийн эрүүл мэндийн төв “Монгол улсад эх, хүүхдэд эмнэлгийн төрөлжсөн мэргэжлийн тусламжийг чанарын өндөр түвшинд, үйлчлүүлэгчээ дээдэлсэн тав тухтай орчинд үзүүлж, дэлхийн жишигт хүрсэн үйлчилгээг эрхэмлэнэ” гэж энэ байгууллагын үйл ажиллагааны эрхэм зорилго, зорилтыг тодорхойлсон байна.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д “Төсвийн байгууллага нь түүний үйл ажиллагааг үр ашигтай удирдлагаар хангаж, ажлын үр дүнг хариуцах үүрэг бүхий төсвийн шууд захирагчтай байна” гэж заасан байна.

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4.18-д “төсвийн бусад байгууллагын дарга(захирал, эрхлэгч) тухайн байгууллагын төсвийн шууд захирагч байна” гэж заасны дагуу тус байгууллагын захирал Төсвийн захирагчийн үүргийг гүйцэтгэж байна. Эх хүүхдийн эрүүл мэндийн төвийн 2016 оны төсвийг Сангийн яамны төрийн сангаас олгож байна.

Төсвийн шууд захирагчтай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд байгууллагатай холбоотой хуулиудыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Эх хүүхдийн эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааны талаар ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын аргазүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2016 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс төсвийн захирагчийн удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансдад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан горим, сорил 28-г гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг 2011 онд боловсруулан мөрдөж байна. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт(УСНББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журамтай нийцэж байна.

Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв “Интерактив Би Ай” ХХК-ийн “Емаральд” санхүүгийн програмыг ашиглаж 2016 оны санхүүгийн тайлангаа тайлагнаж байна.

Материаллаг байдлыг тооцсон тухайд:

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2016 оны 3-р улиралын нийт зардлын 1 хувиар тогтоож, хүлээн зөвшөөрөх алдааны түвшинг 214.7 сая төгрөг гэж тооцсон. Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлыг 2016 оны жилийн эцсийн нийт зардлын дүнгээр түвшинг шинэчлэн тогтоож 299.7 сая төгрөг болгож тооцсон. Учир нь нийт орлого, нийт хөрөнгө, цэвэр хөрөнгийн дүнгүүд өндөр байгаа тул нийт зардлаас тооцох нь зүйтэй гэж үзсэн.

Дотоод хяналт:

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн дотоод хяналт эрсдлийг төлөвлөлтийн үед бага гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналт санхүү, бүртгэл, төсвийн чиглэлээр хангалттай хяналт хийж чаддаггүй байна.

Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:

2016 оны батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийн дагуу Төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн захирагч нь 2016 онд улсын төсвөөс урсгал зардалд 17,362.3 сая төгрөгийн санхүүжилт, эрүүл мэндийн даатгалын сангаас 7,894.4 сая төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоор 719.7 сая төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоор 21.2 сая төгрөг нийт 25,997.6 сая төгрөгийн эх үүсвэртэй ажилласан байна. 2016 онд 26,220.6 сая төгрөгийн төсөв батлагдснаас 25,998.9 сая төгрөгийг зарцуулж батлагдсан төсвийг 221.7 сая төгрөгөөр дутуу зарцуулсан нь төр хариуцах эмийн зардлаас 206.9 сая төгрөг, түлш шатахууны зардлаас 7.7 сая төгрөг, ашиглалтын зардлаас 4.7 сая төгрөг, дотоод томилолтын зардлаас 2.4 сая төгрөгийг хэмнэж ажилласан байна.

Шилэн дансны мэдээлэл

Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв нь Шилэн дансны тухай хуулийн дагуу төсвийн өмч хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор төсвийн захирагчийн шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байхад нийцүүлэн shilendans.gov.mn сайтад батлагдсан маягт хавсралтуудын дагуу төсөв, гүйцэтгэлийн 5.0 сая төгрөгөөс дээш худалдан авах ажиллагаа, бусад зарлагын гүйлгээний мэдээллийг сар бүр шилэн дансанд байршуулж байна.

Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 68 эрсдлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 28 хяналтын болон нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Гол, онцлог гүйлгээний талаарх тайлбар:

Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2016 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний мөнгөн хөрөнгө, бараа материал, хөрөнгө, бусад орлого, тээвэр шатахуун зэрэг дансанд ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа./ТАБ-СТА-В-3/

Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг доор тэмдэглэв. Үүнд:

1. Бараа материалын тайлангийн үлдэгдлийг нягтлан бодох бүртгэлээр гарсан гүйлгээ балансын үлдэгдэлтэй тулган шалгахад 3.2 сая төгрөгөөр зөрүүтэй байгаа нь санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байсан.

Шийдвэрлэсэн нь: Холбогдох ажилтнуудад дээрх алдааг танилцуулж нягтлан бодох бүртгэлийн журналын бичилтэд залруулга хийлгэв.

2. Хуримтлагдсан элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн дахин үнэлгээ хийх шаардлагатай 2,983.9 сая төгрөгийн хөрөнгө байна. УСНББОУС17-ийн /44-58/-ийн дагуу дахин үнэлгээ хийх талаар холбогдох арга хэмжээ авах шаардлагатай байна.

Шийдвэрлэсэн нь: Холбогдох ажилтнуудад асуудлын бүртгэлээр танилцуулж удирдлагад зөвлөмж хүргүүлэв.

3. Завсрын тайланд хийсэн аудитаар тус байгууллагын санхүүгийн байдлын тайлангийн эхний эцсийн үлдэгдлийг тулган шалгахад үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл өмнөх оны аудит хийгдсэн үлдэгдлээс 105.1 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнагдсан байна. Энэ нь санхүүгийн тайлагналын толилуулга ба тодруулга батламж мэдэгдэл хангагдаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Холбогдох ажилтнуудад дээрх алдааг танилцуулж нягтлан бодох бүртгэлийн журналын бичилтэд залруулга хийлгэн санхүүгийн тайланг гаргуулав.

4. ЭХЭМҮТ-ийн ҮЭХ-ноос үнэ төлбөргүй өгсөн 3.1 сая төгрөгийн бага үнэтэй түргэн элэгдэх зүйлсийг данс бүртгэлд тусгаж, тайлагнаагүй байгаа нь Сангийн Сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Төсөвт багууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын 2.12-т "Буцалтгүй тусламжаар ирсэн бэлэг хандивыг хөрөнгө ба орлого гэж хүлээн зөвшөөрнө", "Төрийн болон орон нутгийн өмчийн тухай" хуулийн 6 дугаар зүйлийн 6.2-д "Төсөвт авсан зээл, хандив, дэмжлэг, тусламжаар бий болсон хөрөнгө нь төрийн болон орон нутгийн өмч байна" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Холбогдох ажилтнуудад асуудлын бүртгэлээр танилцуулж удирдлагад зөвлөмж хүргүүлэв.

5. Улсын төсвийн урсгал санхүүжилт, нэмэлт санхүүжилт, төслийн санхүүжилт, нийгмийн даатгалын сангаас олгодог эмчилгээний төлбөр, үйл ажиллагааны орлогуудыг хөөн шалгахад 6,449.1 сая төгрөгийн орлогыг хүлээн зөвшөөрч бүртгэлд тусгахдаа авлагын тооцооны дансаар дамжуулж бүртгэсэн нь Сангийн Сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Төсөвт багууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ыг мөрдөөгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Холбогдох ажилтнуудад дээрх алдааг танилцуулж нягтлан бодох бүртгэлийн журналын бичилтэд залруулга хийлгэв.

6. Цалингийн тооцооны нягтлан бодох бүртгэлийн бичилтийг шалгахад гарт олгох дүнгээр буюу мөнгөн сууриар цалингийн зардалд бүртгэж тайлагнаж байгаа нь Сангийн Сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 1 дүгээр

хавсралтаар батлагдсан "Төсөвт багууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ыг мөрдөөгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Холбогдох ажилтнуудад асуудлын бүртгэлээр танилцуулж удирдлагад зөвлөмж хүргүүлэв.

Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:

Аудитаар нийт 6,557.5 сая төгрөгийн алдааг илэрснийг залруулсан тул залруулагдаагүй алдаа байхгүй болно.

Анхаарал татахуйц бусад чухал асуудал:

Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв “Интерактив Би Ай” ХХК-ний цалингийн “Payroll”, санхүүгийн “Емаральд” програмуудыг хооронд нь холбуулж, цалин хөлсний тооцоог Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан заавар, аргачлалын дагуу үнэн зөв бүртгэж, тайлагнах шаардлагатай.

Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:

Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2016 оны санхүүгийн тайлангийн аудитын явцад гүйцээж мөшгин шалгаж амжаагүй эрсдэлтэй асуудал байхгүй.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2016 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 9,544.5 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 6,557.5 сая төгрөгийн алдааг залруулж, 2,987.0 сая төгрөгийн зөрчилд менежментийн захидлаар удирдлагад зөвлөмж хүргүүлэв.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвд өмнөх оны аудитаар акт албан шаардлага өгөгдөөгүй бөгөөд санхүүгийн үйл ажиллагаанд 4 зөвлөмж өгснийг бүрэн биелүүлж ажиллаж байна. Үүнд:

- Санхүүгийн тайлангаа “Емаральд” санхүүгийн програмаар бүрэн гаргадаг болсон.
- Жижиг мөнгөн сангаас гарсан ажил гүйлгээг баримтын иж бүрдлийг хангаж данс бүртгэлд бүртгэдэг болсон.
- Тайлант оны авлага, өр төлбөрийн үлдэгдлийг харилцагчтай тооцоо нийлж баталгаажуулдаг болсон.
- Бараа материалын үлдэгдлийг санхүүгийн тайланд тусгахдаа нягтлан бодох бүртгэлийн журналын бичилтээс 156.6 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байсныг залруулсан зэрэг биелэлттэй байна.

Зөрчилгүй санал дүгнэлт

Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв илэрхийлэгдсэн байна.

Аудитлагдсан санхүүгийн тайлан ... хуудас, менежментийн захидал ... хуудсыг тус тус хавсаргав.

Аудитын тайланг

Хянасан:

Санхүүгийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор:

С.Энхзаяа

Аудитын менежер:

Н.Золзаяа

Бэлтгэсэн:

“Ньюбаланс аудит” ХХК-ний аудитор:

Д.Гэрэлчулуун

Чанарын менежер:

Ш.Эрдэнэчимэг



УАГ
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

ЭХ ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН 2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

**Нэмэлт мэдээлэл
авахыг хүсвэл дараах
хаягаар харилцана уу:**

Санхүүгийн аудитын
газрын дарга С.Энхзаяа
Утас: 261663

Аудитын менежер
Н.Золзаяа
Утас: 260512

Аудитор Н.Нямдаваа
Утас: 260512

“Ньюбаланс аудит” ХХК
Аудитор Д.Гэрэлчулуун

Тэргүүлэх ач холбогдол №1:

Асуудал 1
Үндсэн хөрөнгийн талаар хуудас 3

Асуудал 2
Орлогын бүртгэлийн талаар хуудас 4

Асуудал 3
Цалингийн тооцооны
бүртгэлийн талаар хуудас 5

МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Үндэсний аудитын газар аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн удирдлагад зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга АОУС-ын дагуу хийгддэг ТАБ-ын аудитын горимоос урган гарсан болно. Бидний хэрэгжүүлсэн горим, сорил нь санхүүгийн тайлангийн санал дүгнэлт гаргахад зориулагдсан.

Тиймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгаж байгаа болно.

Төрийн аудитын байгууллага энэхүү зөвлөмжийг та бүхний бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн санхүүгийн холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

ҮАГ-ын ажиглалт:

Хуримтлагдсан элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн дахин үнэлгээ хийх шаардлагатай 2,983.9 сая төгрөгийн хөрөнгө байна. УСНББОУС17-ийн /44-58/-ийн дагуу дахин үнэлгээ хийх талаар холбогдох арга хэмжээ авах шаардлагатай байна.

ҮАГ-ын зөвлөмж:

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 25.2-д "Зах зээлийн үнэ, валютын ханшны өөрчлөлт зэргийг харгалзан эд хөрөнгийг дахин үнэлэх шийдвэрийг Засгийн газар гаргаж болно" гэж заасны дагуу элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн хөрөнгийн ирээдүйд өгөх эдийн засгийн үр өгөөжийг тооцон, мэргэжлийн байгууллагаар хөрөнгийн бодит үнэлгээг хийлгэж, холбогдох стандарт, заавар журмын дагуу шийдвэрлүүлэх.

Эрсдэл:

- УСНББОУС, холбогдох хууль, заавар, журамд нийцэхгүй байх

Үйлчлүүлэгчийн хариу:

Аудитын асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтнуудад танилцуулж, баталгаажуулсан болно.

ҮАГ-ын ажиглалт:

ЭХЭМҮТ-ийн ҮЭХ-ноос үнэ төлбөргүй өгсөн 3.1 сая төгрөгийн бага үнэтэй түргэн элэгдэх зүйлсийг данс бүртгэлд тусгаж, тайлагнаагүй байгаа нь Сангийн Сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Төсөвт багууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын 2.12-т "Буцалтгүй тусламжаар ирсэн бэлэг хандивыг хөрөнгө ба орлого гэж хүлээн зөвшөөрнө", "Төрийн болон орон нутгийн өмчийн тухай" хуулийн 6 дугаар зүйлийн 6.2-д "Төсөвт авсан зээл, хандив, дэмжлэг, тусламжаар бий болсон хөрөнгө нь төрийн болон орон нутгийн өмч байна" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

ҮАГ-ын зөвлөмж:

Холбогдох хууль тогтоомж, журам, заавар, аргачлалыг хэрэгжүүлж ажиллах

Эрсдэл:

- Санхүүгийн тайланг үнэн зөв тайлагнахгүй байх

Үйлчлүүлэгчийн хариу:

Аудитын асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтнуудад танилцуулж, баталгаажуулсан болно.

ҮАГ-ын ажиглалт:

Цалингийн тооцооны нягтлан бодох бүртгэлийн бичилтийг шалгахад гарт олгох дүнгээр буюу мөнгөн сууриар цалингийн зардалд бүртгэж тайлагнаж байгаа нь Сангийн Сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Төсөвт багууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ыг мөрдөөгүй байна.

ҮАГ-ын зөвлөмж:

“Интерактив Би Ай” ХХК-ний цалингийн “Payroll”, санхүүгийн “Емаральд” програмуудыг хооронд нь холбуулж, цалин хөлсний тооцоог Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан "Төсөвт багууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ыг мөрдөж ажиллах.

Эрсдэл:

- Цалингийн тооцооны данс бүртгэлийг үнэн зөв бүртгэхгүй байх.

Үйлчлүүлэгчийн хариу:

Аудитын асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2016 оны 12 сарын 31

Байгууллагын нэр: ЭХ ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ

/төгрөгөөр/

БАЛАНСЫН ЗҮЙЛ	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
НИЙТ ХӨРӨНГӨ		
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ		
МӨНГӨН ХӨРӨНГӨ	1,500,000.00	-
Авлага	72,545,589.72	807,411.00
Бусад авлага	-	
БАРАА МАТЕРИАЛ	2,953,990,250.78	3,459,745,497.32
Хангамжийн материал	596,410,197.06	674,708,048.82
Тусгай зориулалтын материал	2,357,580,053.72	2,785,037,448.50
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	3,028,035,840.50	3,460,552,908.32
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	39,456,254,488.41	53,071,014,050.80
Биет хөрөнгө	39,347,586,198.16	52,914,028,762.11
Барилга байгууламж	41,702,665,479.00	41,712,539,147.00
Хуримтлагдсан элэгдэл	(17,873,642,404.54)	(18,622,122,217.84)
Авто тээврийн хэрэгсэл	328,966,980.00	389,966,980.00
Хуримтлагдсан элэгдэл	(196,080,015.06)	(246,749,975.21)
Машин,тоног төхөөрөмж	18,594,676,096.37	35,981,473,619.63
Хуримтлагдсан элэгдэл	(5,873,314,118.20)	(8,546,669,011.74)
Тавилга, аж ахуйн эд хогшил	2,710,800,369.27	2,810,431,209.27
Хуримтлагдсан элэгдэл	(793,108,632.45)	(1,216,165,237.11)
Номын фонд	18,480,206.90	19,079,870.90
Бусад үндсэн хөрөнгө	1,078,099,447.56	1,078,099,447.56
Хуримтлагдсан элэгдэл	(349,957,210.69)	(445,855,070.35)
Биет бус хөрөнгө	108,668,290.25	156,985,288.69
Программ хангамж	185,537,720.00	287,613,849.48
Хасагдуулга	(76,869,429.75)	(130,628,560.79)
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	39,456,254,488.41	53,071,014,050.80
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	42,484,290,328.91	56,531,566,959.12
Богино хугацаат өр төлбөр	51,950,771.00	
Өглөг		
Ажиллагчидтай холбогдсон өглөг		
Бараа үйлчилгээний зардлын өглөг	50,955,071.00	
Бусад өглөг	995,700.00	
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	51,950,771.00	-
НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	51,950,771.00	-
Засгийн газрын оруулсан капитал	13,524,707,599.80	13,524,707,599.80
Өмнөх үеийн үр дүн	(775,875,947.03)	10,209,921,630.57
Тайлант үеийн үр дүн	10,985,797,577.60	14,099,227,401.21
Дахин үнэлгээний зөрүү	18,697,710,327.54	18,697,710,327.54
ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	42,432,339,557.91	56,531,566,959.12
ӨР ТӨЛБӨР,ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	42,484,290,328.91	56,531,566,959.12

Баталгаажуулсан: Аудитор:

/Д.Гэрэлчулуун/

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

2016 оны 12 сарын 31

Байгууллагын нэр: ЭХ ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ

/төгрөгөөр/

БАЛАНСЫН ЗҮЙЛ	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО	37,552,714,299.80	44,064,333,458.68
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	23,225,150,131.76	25,487,940,694.08
Засгийн газрын бусад түвшнээс авах тусламж санхүүжилт		
Улсын төвлөрсөн төсвөөс	15,802,940,693.81	17,362,347,999.12
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	15,802,940,693.81	17,362,347,999.12
Төсөвт байгууллагаас		
Төвлөрүүлэх шилжүүлэг		
Үдийн цай санхүүжилтийн орлого		
Өр барагдуулах санхүүжилтийн орлого		
нийгмийн даатгалын сангаас	7,136,723,241.00	7,894,399,481.00
Нийгмийн даатгалын шилжүүлэг		
ТАТВАРЫН БУС ОРЛОГО		
Бараа, үйлчилгээний борлуулалт		
Төсөвт байгууллагуудын ажил, үйлчилгээний орлого	425,761,916.00	719,697,785.00
Үндсэн бус үйл ажиллагааны орлого	36,415,261.00	48,488,694.00
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	285,486,196.95	231,193,213.96
төсвийн жилийн явцад ОУБ-аас өгсөн санхүүжилт	397,507,700.00	146,387,497.04
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	49,222,372.15	51,740,800.00
Дээд шатны төсвийн захирагчаас өгсөн санхүүжилт	2,050,578,050.89	17,356,486,898.48
Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламж	11,368,078,868.00	234,886,178.26
Бусад орлого		18,704,911.82
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	37,552,714,299.80	44,064,333,458.68
АЖИЛЛАГСАДТАЙ ХОЛБОГДСОН ЗАРДАЛ	14,796,168,479.35	14,965,426,270.48
Үндсэн болон нэмэгдэл цалин	13,329,412,821.57	13,588,081,203.08
Нийгмийн хамгааллын шимтгэл	1,466,755,657.78	1,377,345,067.40
Тэтгэвэр болон тэтгэмжийн шимтгэл	1,040,214,447.51	1,160,410,548.57
Тэтгэврийн даатгалын шимтгэл	933,579,144.94	1,105,859,662.70
Тэтгэмжийн даатгалын шимтгэл	106,635,302.57	54,550,885.87
ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	133,294,128.20	67,517,926.59
Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	26,658,825.64	14,112,465.07
Эрүүл мэндийн даатгалын хураамж	266,588,256.43	135,304,127.17
Бараа үйлчилгээний урсгал зардал	11,740,940,903.33	14,999,679,786.99
Тогтмол зардал	966,091,401.47	1,154,112,069.46
Гэрэл цахилгаан	359,402,630.50	437,658,569.54
Түлш, халаалт	321,204,298.00	397,705,259.92
Цэвэр, бохир ус	285,484,472.97	318,748,240.00
Үйл ажиллагааны зардал	7,073,570,792.99	8,330,079,542.70
Хоол	862,355,831.00	870,921,221.63
Эм вакцин	6,211,214,961.99	7,459,158,321.07
Бусад бараа үйлчилгээний зардал	3,534,901,065.87	5,101,216,774.83
Бичиг хэргийн зардал	84,019,938.00	71,587,050.31
Тээвэр, шатахуун	31,935,799.53	28,947,132.11
Шуудан, харилцаа холбоо	18,673,921.33	22,397,782.22
Дотоод албан томилолт	3,313,880.00	31,591,048.00
Ном, хэвлэл захиалах, худалдан авах	587,600.00	6,119,479.00
Жижиг эд хогшил худалдан авах	262,459,933.57	253,389,269.96
Бага үнэтэй түргэн элэгдэх зүйл	11,656,306.00	16,389,252.14
Нормын болон дүрэмт хувцас ,зөөлөн эдлэл	113,951,658.80	122,087,025.82
Төлбөр хураамж жижиг татварууд	8,968,242.00	6,491,400.00
Урсгал засвар	202,705,450.60	175,343,821.64
Үндсэн хөрөнгийн элэгдэл	2,616,977,571.74	4,045,218,262.35
Бараа үйлчилгээний бусад зардал		278,174,661.28

Бараа материал акталсаны зардал		
Хөтөлбөр арга хэмжээний зардал	11,906,172.00	6,960,000.00
Төсвийн эрх захирагчдын арга хэмжээний зардал		
Сургалт хурал зөвлөлгөний зардал		
Хичээл үйлдвэрлэлийн дадлага, сургуулилалтын зардал	167,744,592.30	36,520,590.00
ЗАСГИЙН ГАЗРЫН БАЙГУУЛЛАГА, НЭГЖҮҮДЭД ОЛГОСОН		
Төсвийн ерөнхийлөн захирагчидад олгосон санхүүжилт		
Төвлөрүүлэх шилжүүлэг		
НИЙГМИЙН ХАМГААЛАЛЫН ЗАРДАЛ	166,377,643.00	414,271,400.00
Ажил олгогчоос өгөх бусад тэтгэмж		
Мөнгөн хэлбэрээр		
Нэг удаагийн тэтгэмж	41,457,500.00	414,271,400.00
Бусад	124,920,143.00	
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	26,537,109,382.68	29,965,106,057.47
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	11,015,604,917.12	14,099,227,401.21
Бусад зардал ба алдагдал		
Хөрөнгө худалдсаны гарз	29,807,339.52	
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН	10,985,797,577.60	14,099,227,401.21

Баталгаажуулсан: Аудитор:

/Д.Гэрэлчулуун/

АУДИТ ХИЙГДСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

2016 оны 12 сарын 31

Байгууллагын нэр: ЭХ ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2014 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	13,524,707,599.80	18,697,710,327.54	(775,875,947.03)	31,446,541,980.31
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				-
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл				-
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				-
5	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				-
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				-
7	Тайлант үеийн үр дүн			10,985,797,577.60	10,985,797,577.60
8	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	13,524,707,599.80	18,697,710,327.54	10,209,921,630.57	42,432,339,557.91
9	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				-
10	Дахин илэрхийлсэн үлдэгдэл				-
11	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				-
12	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				-
13	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				-
14	Тайлант үеийн үр дүн			14,099,227,401.21	14,099,227,401.21
15	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	13,524,707,599.80	18,697,710,327.54	24,309,149,031.78	56,531,566,959.12

Баталгаажуулсан: Аудитор:

/Д.Гэрэлчулуун/

АУДИТ ХИЙГДСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2016 оны 12 сарын 31

Байгууллагын нэр: ЭХ ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ

/төгрөгөөр/

БАЛАНСЫН ЗҮЙЛ	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГО	23,961,127,744.59	26,614,064,508.62
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		
Гадаад орнуудаас үзүүлсэн		
Урсгал		
Хөрөнгийн		
Олон улсын байгууллагын тусламж		
Урсгал тусламж	298,652,900.00	
Хөрөнгийн тусламж		
Засгийн газрын бусад түвшнээс авах тусламж санхүүжилт		
Улсын төвлөрсөн төсвөөс		
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	15,811,696,886.00	17,582,823,100.00
Төвлөрүүлэх шилжүүлэг		
Засгийн газрын нөөц хөрөнгө		
Төсвийн хуваарилаагүй зардал		
Хөрөнгийн		
Оны эхний үлдэгдлээс санхүүжих	128,739,037.44	
Дээд шатны төсвийн захирагчаас өгсөн санхүүжилт		396,155,605.62
Бусад шатны (Орон нутгийн) төсвөөс авах санхүүгийн дэмжлэг		
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	98,854,800.00	
Төвлөрүүлэх шилжүүлэг		
Засгийн газрын нөөц хөрөнгө		
Төсвийн хуваарилаагүй зардал		
Хөрөнгийн		
Төсөвт байгууллагаас		
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		
Төвлөрүүлэх шилжүүлэг		
Үдийн цай санхүүжилтийн орлого		
өр барагдуулах санхүүжилтийн орлого		
Хөрөнгийн		
ТЕЗ-аас олгосон санхүүжилт		
Нийгмийн даатгалын сангаас		
Нэг иргэнд нормативаар олгох зардал		
ЭМДС-аас эмнэлгүүдэд олгох санхүүжилт	7,112,223,572.00	7,894,399,481.00
Үндсэн үйл ажиллагааны орлого	425,761,916.00	719,505,785.00
Үндсэн бус үйл ажиллагааны орлого	35,976,261.00	21,180,537.00
өмнөх оны төлөвлөгөөнөөс давсан өөрийн орлого		
Урьд оны төсвийн хэмнэлтийн орлого	49,222,372.15	
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	23,961,127,744.59	26,614,064,508.62
АЖИЛЛАГЧИДТАЙ ХОЛБОГДСОН ЗАРДАЛ	14,695,922,840.35	14,926,431,322.20
Үндсэн болон нэмэгдэл цалин	13,229,167,182.57	13,448,637,642.20
Үндсэн цалин	11,199,739,763.57	11,377,554,142.20
Нэмэгдэл цалин		
Бусад нэмэгдлүүд		
Үр дүнгийн урамшуулал	1,174,140,919.00	1,225,288,700.00
Илүү цагийн нэмэгдэл		
Унаа, болон бусад нөхөн олговор	855,286,500.00	845,794,800.00
Бусад нэмэгдэл		
Бүтцийн өөрчлөлт хийх цалингийн сан		
Гэрээт ажилчдын цалин		
Унаа, хоолны хөнгөлөлт		
Нийгмийн хамгааллын шимтгэл	1,466,755,657.78	1,477,793,680.00
Тэтгэвэр болон тэтгэмжийн шимтгэл	1,040,193,391.49	1,477,793,680.00
Тэтгэврийн даатгалын шимтгэл	933,552,824.92	1,477,793,680.00

Тэтгэмжийн даатгалын шимтгэл	106,640,566.57	
ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	133,300,708.22	
Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	26,660,141.64	
Бүтцийн өөрчлөлтийн цалингийн НДШ		
Эрүүл мэндийн даатгалын хураамж	266,601,416.43	
Бүтцийн өөрчлөлтийн цалингийн ЭМД-ын шимтгэл		
УРСГАЛ ЗАРДАЛ		
Бараа үйлчилгээний урсгал зардал	8,958,515,301.24	10,892,413,930.50
Тогтмол зардал	966,091,401.47	1,139,349,069.46
Гэрэл цахилгаан	359,402,630.50	453,533,867.46
Түлш, халаалт	321,204,298.00	367,066,962.00
Цэвэр, бохир ус	285,484,472.97	318,748,240.00
Үйл ажиллагааны үндсэн үзүүлэлттэй шууд холбоотой	6,646,449,135.14	8,181,837,689.94
Хоол	863,203,636.00	864,925,088.00
Эм, вакцин	5,783,245,499.14	7,316,912,601.94
Бусад бараа үйлчилгээний зардал	1,345,974,764.63	1,571,227,171.10
Бичиг хэргийн зардал	59,788,590.00	24,368,660.00
Тээвэр, шатахуун	28,228,050.00	34,560,400.00
Шуудан, харилцаа холбоо	18,634,221.33	24,460,982.22
Дотоод албан томилолт	3,313,880.00	33,057,649.00
Гадаад албан томилолт		
Ном, хэвлэл захиалах, худалдан авах	587,600.00	
Хичээл, үйлдвэрлэлийн дадлага		
Сургалт семинарын зардал		
Эрдэм шинжилгээний ажил хийх		
Жижиг эд хогшил худалдан авах		
Багаж хэрэгсэл худалдан авах	130,190,633.50	75,806,385.00
Хөдөлмөр хамгаалалын хэрэгслэл	6,295,659.00	2,330,450.00
Бага үнэтэй түргэн элэгдэх зүйл	130,190,633.50	56,948,115.00
Нормын болон дүрэмт хувцас, зөөлөн эдлэл	215,988,000.00	318,055,061.50
Төлбөр хураамж, жижиг татварууд	235,000.00	36,500.00
Харуул, хамгаалалтын зардал		
Банкны үйлчилгээний хураамж	34,400.00	
Төрийн өмнөөс гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр өмгөөлөл, хуулийн зөвлөх үйлчилгээний хөлс		99,318,332.00
Нийтэд үйлчилгээ үзүүлэх Засгийн газрын бус байгууллага Нормативаар тоо		
Бараа үйлчилгээний бусад зардал	184,616,065.00	504,374,219.38
Эрдэс шинжилгээ судалгааны ажлын хөлс		
Төрийн өмнөөс гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ		
Ажил олгогчийн урамшуулал		
Мэдээлэлийн технологийн үйлчилгээний хөлс	6,377,180.00	
Аудит баталгаажуулалт зэрэглэл тогтоох үйлчилгээний хөлс /гадаад/		
Банк санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	34,400.00	104,900.00
Аудит баталгаажуулалт зэрэглэл тогтоох үйлчилгээний хөлс/дотоод/	3,060,000.00	6,960,000.00
Эд хөрөнгийн даатгал		
Тээврийн хэрэгслэлийн даатгал	350,000.00	350,000.00
Галын даатгал		
Харуул хамгаалалтын хөлс		
Тээврийн хэрэгслэлийн оношлогоо	35,800.00	68,000.00
Маягт хэвлүүлэх зардал		40,981,920.00
Урсгал засвар	130,855,341.00	81,982,349.00
Биеийн тамирын уралдаан, тэмцээний зардал		
Гадаадын зочны зардал		
Холбооны шугам ашигласны зардал		
Засварын зардал		
Аж ахуйн материал худалдан авах зардал		
Газрын төлбөр	5,253,042.00	5,932,000.00
Улсын мэдээллийн маягтын зардал		
Ажил, үйлчилгээний хөлс		

Хог хаягдал устгах цэвэрлэх	209,527,672.00	261,531,248.00
Байрны түрээс		
Үдийн цай		
Улсын мэдээлэлийн маягт бэлтгэх		
Товхимол тараах материал		
Хөтөлбөр арга хэмжээний зардал		
Нийтийг хамрах аюул болон үйлд ноцтой осол гарсантай		
Бусад төсөл арга хэмжээ	212,378,597.30	
Баяр наадмын зардал		
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ҮНДСЭН ХӨРӨНГИЙН АШИГЛАЛТ	64,691,960.00	315,155,107.92
Төвлөрүүлэх шилжүүлэг	64,691,960.00	315,155,107.92
Засгийн газрын нөөц хөрөнгө		
Төсвийн хуваарилаагүй зардал		
Хөрөнгийн		
Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас,		
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		
Төвлөрүүлэх шилжүүлэг		
Засгийн газрын нөөц хөрөнгө		
Төсвийн хуваарилаагүй зардал		
Хөрөнгийн		
Төсөвт байгууллагад олгох санхүүжилт		
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		
Төвлөрүүлэх шилжүүлэг		
Засгийн газрын нөөц хөрөнгө		
Төсвийн хуваарилаагүй зардал		
Хөрөнгийн		
Нийгмийн даатгалын санд олгох татаас		
Төр хариуцах иргэдийн ЭМД хураамж		
Тэтгэвэрийн нөхөн олговор авагчдын НДШ		
НДС: Тэтгэвэрийн ДС-д олгох татаас		
ЭМДС олгосон татаас		
Нэг иргэнд нормативаар олгох татаас		
ЭМДС-аас эмнэлгүүдэд олгох санхүүжилт		
ЭМД-аас эмийн хөнгөлөлтөд олгох бусад зардал		
НДС-ийн үйл ажиллагааны зардал		
ЭМДС-ийн үйл ажиллагааны зардал		
Тусгай зориулалтын сан болон бусад		
Төрийн сургалтын санд олгох татаас		
Төрийн албан хаагчийн 1 хүүхдийн сургалтын төлбөр		
Буцалтгүй тусламжаар суралцагчдын тэтгэлэг		
Гадаад оюутны сургалтын төлбөр		
Гадаадад суралцагсдад олгох тэтгэлэг		
Соёл урлаг хөгжүүлэх санд олгох татаас		
Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан		
Замын санд олгох татаас		
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЗАРДАЛ		
Нийгмийн даатгалын зардал		
Нийгмийн даатгалын зардал		
Өндөр настны тэтгэвэр		
Тахир дутуу бологсдын тэтгэвэр		
Тэжээгчээ алдсаны тэтгэвэр		
Цэргийн тэтгэвэр		
Тэтгэвэрийн нөхөн олговор		
Тэтгэмжийн даатгалын сан		
Хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмж		
Жирэмсэний, амаржсаны эхийн тэтгэмж		
Оршуулагын тэтгэмж		
ҮОМШӨ-ний тэтгэвэр, тэтгэмж		
Тахир дутуугийн		
Тэжээгчээ алдсаны		
Хөдөлмөрийн чадвар түр алдсаны		
Хөдөлмөрийн чадварыг нөхөн сэргээхтэй холбогдсон		

Мэргэжлийн өвчин судлалын төв		
Ажилгүйдлийн тэтгэмж		
Ажилгүйдлийн тэтгэмж		
Нийгмийн халамжийн зардал		
Халамжийн тэтгэвэр		
Жирэмсэн, амарсан эхийн тэтгэмж		
Нярай хүүхэдтэй эхийн тэтгэмж		
Олон хүүхэдтэй эхийн тэтгэмж		
Хүүхдийн арчилгааны тэтгэмж		
Ихэр хүүхдийн тэтгэмж		
Бүтэн өнчин хүүхэд үрчлэн авч өсгөсний тэтгэмж		
Өндөр настан, ахмад дайчдад олгох хөнгөлөлт		
Тахир дутуу хүмүүст үзүүлэх хөнгөлөлт		
Улсын баатар, партизануудад үзүүлэх хөнгөлөлт		
Халамжийн бусад хөнгөлөлт, үйлчилгээ		
Улсын баатрын одонгийн шагнал		
Ахмад дайчдад олгох нэг удаагийн тэтгэмж		
Бусад тэтгэмж		
Ажил олгогчоос өгөх бусад тэтгэмж	166,377,643.00	415,171,400.00
Мөнгөн хэлбэрээр		
Нэг удаагийн тэтгэмж	41,457,500.00	414,271,400.00
Бусад	124,920,143.00	900,000.00
Биет хэлбэрээр		
БУСАД ЗАРДАЛ	-	-
Бусдийн өмчийг ашигласаны зардал/түрээсийн зардал		
Байрны түрээс		
Суваг ашигласаны зардал		
Бусад		
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН	23,885,507,744.59	26,549,171,760.62
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	75,620,000.00	64,892,748.00
Үндсэн хөрөнгө борлуулсаны орлого		
Бусад хөрөнгийн борлуулалтын орлого		
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН		
Биет ба биет бус хөрөнгө худалдан авах зардал	74,120,000.00	66,392,748.00
Хөрөнгийн бусад зардал		
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН	74,120,000.00	66,392,748.00
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
Байгууллагаас авах авлага		
Авсан зээл		
Төлсөн зээл		
САНХҮҮГИЙН АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН		
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	1,500,000.00	(1,500,000.00)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		1,500,000.00
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,500,000.00	-

Баталгаажуулсан: Аудитор:

/Д.Гэрэлчулуун/

ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ ТАЙЛАН

2016 оны 12 сарын 31

Байгууллагын нэр: ЭХ ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ

/төгрөгөөр/

д/д	Эдийн засгийн ангилал	Батлагдсан төсөв	Төсвийн гүйцэтгэл	Зөрүү	
				/+илүү, -дуу/	Хувь
1	I.НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II+V)	26,220,258,000.0	25,998,929,802.1	221,328,197.9	99.2%
2	II.НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН (III+IV)	26,220,258,000.0	25,998,929,802.1	221,328,197.9	99.2%
3	III. УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	26,220,258,000.0	25,998,929,802.1	221,328,197.9	99.2%
4	Бараа ажил үйлчилгээний зардал	25,805,986,600.0	25,584,658,402.1	221,328,197.9	99.1%
5	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	13,428,953,000.0	13,428,953,000.0	-	100.0%
6	Үндсэн цалин	11,357,869,500.0	11,357,869,500.0	-	100.0%
7	Нэмэгдэл цалин	845,794,800.0	845,794,800.0	-	100.0%
8	Хоол унааны хөнгөлөлт	1,225,288,700.0	1,225,288,700.0	-	100.0%
9	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,477,184,800.0	1,477,793,680.0	(608,880.0)	100.0%
10	Тэтгэвэр болон тэтгэмжийн шимтгэл	1,477,184,800.0	1,477,793,680.0	(608,880.0)	100.0%
11	Тэтгэврийн даатгал	1,477,184,800.00	1,477,793,680.00	(608,880.0)	100.0%
15	Байгууллага төлөх ЭМД-ын хураамж			-	
16	Байр ашиглалттай холбоотой тогтмол	1,144,115,900.0	1,139,349,069.5	4,766,830.5	99.6%
17	Гэрэл цахилгааны зардал	454,961,500.0	453,533,867.46	1,427,632.5	99.7%
18	Түлш, халаалтын зардал	367,748,000.0	367,066,962.00	681,038.0	99.8%
19	Цэвэр, бохир усны зардал	321,406,400.0	318,748,240.00	2,658,160.0	99.2%
22	Бичиг хэргийн материал	9,557,400.0	11,622,250.00	(2,064,850.0)	121.6%
23	Тээвэр, шатахууны зардал	42,288,300.0	34,560,400.00	7,727,900.0	81.7%
24	Шуудан холбооны зардал	21,936,800.0	24,460,982.22	(2,524,182.2)	111.5%
25	Хог хаягдал устгах цэвэрлэх	251,155,200.0	261,531,248.00	(10,376,048.0)	104.1%
	Бага үнэтэй түргэн элэгдэх зүйл	68,133,800.0	61,852,395.00	6,281,405.0	90.8%
26	Дотоод томилолтын зардал	6,067,600.0	3,458,300.00	2,609,300.0	57.0%
27	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил,үйлчилгээний төлбөр	93,192,000.0	93,192,000.00	-	100.0%
28	Тээврийн хэрэгслийн татвар оншилгоо	388,000.0	104,500.00	283,500.0	26.9%
29	Аудит, баталгаажуулалтын зардал	6,960,000.0	6,960,000.00	-	100.0%
30	Даатгалын үйлчилгээ	350,000.0	350,000.00	-	100.0%
31	Газрын төлбөр	5,932,000.0	5,932,000.00	-	100.0%
32	Жижиг эд хогшил худалдан авах зардал			-	
33	Зөөлөн эдлэл, нормын хувцас худалдан авах зардал	315,813,600.0	318,781,061.50	(2,967,461.5)	100.9%
34	Хоол	863,204,500.0	863,203,799.00	701.0	100.0%
35	Эм	7,545,691,200.0	7,338,802,601.94	206,888,598.1	97.3%
36	Ном хэвлэл авах	41,010,600.0	40,981,920.00	28,680.0	99.9%
37	Урсгал засварын зардал	126,049,600.0	125,450,619.00	598,981.0	99.5%
	Бараа ажил үйлчилгээний бусад зардалд	358,002,300.0	347,318,576.00	10,683,724.0	97.0%
38	Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх			-	
39	Татаас			-	
40	Бусад урсгал шилжүүлэг			-	
41	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал			-	
42	Биеийн тамирын уралдаан, тэмцээний			-	
43	Байрны түрээсийн зардал			-	
44	Холбооны суваг ашигласны зардал			-	
45	Нэг удаагийн тэтгэмж, урамшуулал			-	
46	Нэг удаагийн тэтгэмж, урамшуулал	414,271,400.0	414,271,400.00	-	100.0%
47	Төвлөрүүлэх шилжүүлэг			-	
48	V. ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ			-	
49	VI. ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ	26,220,558,000.0	25,998,929,802.1	221,628,197.9	99.2%
50	Туслах үйл ажиллагааны орлогоос	38,209,400.0	21,180,537.0	17,028,863.0	55.4%
51	Үндсэн үйл ажиллагааны орлого	658,076,400.0	719,505,785.0	(61,429,385.0)	109.3%
52	Эрүүл мэндийн даатгалаас санхүүжих	7,941,449,100.0	7,894,399,481.0	47,049,619.0	99.4%
53	Төсвөөс санхүүжих	17,582,823,100.0	17,362,343,999.1	220,479,100.9	98.7%
54	Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл		1,500,000.0	(1,500,000.0)	
55	Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл		-		
56	Байгууллагын тоо	1	1	-	
57	Ажиллагсад бүгд	1,127	1,128	(1)	
58	Удирдах ажилтан	1	1	-	
59	Гүйцэтгэх ажилтан	741	846	(105)	
60	Үйлчлэх ажилтан	383	279	104	
61	Гэрээт ажилчид	2	2	-	

Баталгаажуулсан: Аудитор:

/Д.Гэрэлчулуун/

